



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/243

Есөнбулаг сум

Газар эзэмших эрхийн дуудлага
худалдаа зохион байгуулах ажлын
хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2025 оны А/168 дугаар захирамжаар зарлагдсан газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга:	Д.Чинзориг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд:	Х.Лхагважав	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
	Н.Пүрэвдулам	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	А.Пүрэвсэд	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газрын удирдлагын хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Д.Мөнхтуяа	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж, газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, шалгаруулалтын үр дүнг танилцуулахыг комисс (Д.Чинзориг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

